

12. “Эрчүүд нь эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой ч эмэгтэйчүүд гэртээ эрчүүдийн хүслээр амьдрах ёстой” хэмээн ямар хуульд заасан байдаг вэ?
- а. Манугийн хууль б. Хаммурапихааны хууль
в. 12 Зэс самбарын хууль г. Их засаг хууль
13. . Дөрвөлжин булш аль үеийн дурсгал вэ?
- а. Шинэ чулуун зэвсгийн үе б. Хүрэл ба Төмөр зэвсгийн үе
в. Төмөр зэвсгийн үе г. Зэс зэвсгийнүе
14. Аль эх сурвалжийг байлдааны, аж ахуйн, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой гэж ангилдаг вэ?
- а.Түүвэр олдвор б.Урлаг в.Хадны зураг г.чулуун зэвсэг
15. Эртний Хятадын иргэншил ямар мөрний хөндийг даган үүссэн бэ?
- а. Инд мөрөн б. Тигр, Евфрат мөрөн в. Шар мөрөн г. Нил мөрөн
16. Дугуй хүрээ чулуутай голдоо дугуй чулуун дараас бүхий эртний оршуулгын байгууламж аль нь вэ?
- а. Хиригсүүр б. Бунхан в. Дөрвөлжин булш г. Гэр булш
17. Дэлхийн хамгийн эртний улсыг нэрлэнэ үү.
- а. НТӨ 3200-2350 б. НТӨ 2060-НТӨ1500 в.НТӨ1500-500 г. НТӨ 3200-2050
18. Египетид хэддүгээр мянганы үеэс хот байгуулагдаж эхэлсэн бэ?
- а.НТӨ-II мянган б.НТӨ-III мянган в. НТӨ-IV мянган г.НТӨ-V мянган
19. Хятадын "Цагаан хэрэм"-ийг барих болсон шалтгаан юу вэ?
- а. Вэй улсын довтолгооноос хамгаалахын тулд
б Чингис хааны довтолгооноос хамгаалахын тулд
в. Хүннүчүүд болон тэр үеийн нүүдэлчдийн довтолгооноос хамгаалахын тулд
г. Умард Алтан улсын довтолгооноос хамгаалахын тулд
20. . Демократ” засаглал гэж ямар засаглал вэ?
- а. Олонхийн засаглал б. Цөөнхийн засаглал
в. Хаант засаглал г. Дарангуйлалын засгалал
21. Хүн төрөлхтний эртний иргэншил үүссэн Нил мөрөн хаанаас эх авч хаана цутгадаг вэ?
- а. Төвдийн тэгш өндөрлөгөөс эх авч Шар тэнгис цутгана
б. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч Газар дундын тэнгист цутгана.
в. бага Азийн өндөр уулсаас эх авч Персийн буланд цутгана
г. Андын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.
22. Хүннү улс НТӨ 209 онд байгуулагджээ. Оныг зуунд шилжүүлнэ үү
- а. НТӨ II зууны I хагас б. НТӨ III зууны I хагас
в. НТӨ II зууны II хагас г. НТ III зууны Iхагас
23. Сяньби улсын оршин тогтнож байсан хугацаа аль нь вэ?
- а. НТӨ 209-НТ 93 он б. НТӨ II-I зуун в. 156-235 он г. 555-745 он

24. Монгол нутагт байгуулагдсан Монгол угсаатны эртний улсаас хамгийн богино хугацаанд оршин тогтносон нь аль вэ?
- а. Хүннү б. Сяньби в. Нирун г. Кидан
25. Сяньби улсын үндсэн аж ахуй нь
- а. Газар тариалан б. Гар урлал в. Мал аж ахуй г. Ан агнуур
26. Монгол нутаг дахь эртний улсуудыг оршин байсан дарааллаар нь зөв эрэмбэлснийг олно уу.
- а. Хүннү, Сяньби, Нирун, Уйгар, Түрэг б. Хүннү, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар
в. Хүннү, Нирун, Сяньби, Түрэг, Уйгар г. Хүннү, Сяньби, Уйгар, Түрэг, Нирун
27. НТӨ 198 онд Хүннү гүрэн Хан улсын хооронд анхны гэрээ байгуулагдсан бөгөөд уг гэрээний үр дүнг доорх өгөгдлөөс сонгоно уу.
- а. Хан улс Хүннүгийн харьяат болсон
б. Хүннү улс Хан улсад дагаар орсон
в. Хоёр тал хилээ тогтоож Хан улс Хүннүд алба татвар төлөх болсон
г. Хүннү улс Хан улсад алба татвар өгөхөөр болсон
28. Хүннүчүүд бичиг үсэгтэй байсан гэж үзэх шалтгааныг доорх өгөгдлөөс сонгоно уу.
- а. Тэдний Хан улсад явуулсан захидал Хятад улсын музейд бий
б. Хүннү улсын түүхийг өгүүлсэн бичээс бүхий хад олдсон
в. Хүннүгийн булшнаас бэхийн дусалтай бийрний нийлүүр олдсон
г. Ноён уулнаас олдсон ширмэл ширдэгт тэдний бичиг үсгийн дурсгал үлдсэн
29. Хойд цэнхэрийн агуйн зурагт дүрслэгдсэн амьтдыг харахад тэр үед Монгол орны уур амьсгал ямар байсныг сонгоно уу.
- а. Мөстлөгийн үеийн буюу хүйтэн уур амьсгалтай
б. Эрс тэс уур амьсгалтай
в. Халуун хуурай уур амьсгалтай
г. Чийглэг дулаан уур амьсгалтай
30. 1991 онд Альпийн нуруунаас 5200 жилийн өмнө амьдарч байсан хүнийг олж Өтци хэмээн нэрлэсэн. Энэ хүн ямар багаж зэвсэгтэй байсан бэ?
- а. Чулуугаар хийсэн багаж зэвсэгтэй байсан
б. Жад барьсан байсан
в. Нум сумтай байсан
г. Хүрлээр хийсэн багаж зэвсэгтэй байсан
31. 1889 онд Оросын эрдэмтэд үл мэдэгдэх бичээс бүхий аварга хөшөөг олжээ. Түүнийг 1893 онд хөшөөний бичгийг тайлж уншсан бөгөөд энэ нь ямар бичгийн дурсгалд хамаарагдах вэ?
- а. Уйгар бичгийн б. Согд бичгийн в. Монгол бичгийн г. Руни бичгийн
32. Хүмүүс хэдий үеэс галыг хэрэглэж эхэлсэн бэ?
- а. Хуучин чулуун зэвсгийн эхэн үе б. Дунд чулуун зэвсгийн сүүл үе
в. Хуучин чулуун зэвсгийн дунд үе г. Шинэ чулуун зэвсгийн эхэн үе
33. Хүмүүс байгальд буй бэлэн үр жимсийг түүж идэхээ больж түүний заримыг нь тарьж ургуулах болсон. Энэ нь аль үед хамаарах вэ?
- а. Шинэ чулуун зэвсгийн үе б. Дунд чулуун зэвсгийн үе
в. Хуучин чулуун зэвсгийн үе г. Хүрэл зэвсгийн үе

34. Уг эх сурвалжийг байлдааны, аж ахуйн, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой гэж ангилдаг. Тохирох хариултыг сонгоно уу.

- а.Түүвэр олдвор б. Урлаг в. Хадны зураг г. чулуун зэвсэг

35. Эргүнэ гүний домгийн гол агуулгыг зөв тодорхойлсныг сонгоно уу.

- а. Түрэг аймгийг Монголчууд цохин мөхөөж тэд Эргүнэ гүнд очиж нутагласан
б. Түрэгүүдэд цохигдсон Монголчууд Эргүнэ гүнд очиж нутаглан өсөж үржсэн
в. Эргүнэ гүнд Монголчууд 1000 орчим жил амьдарсан
г. Эргүнэ гүнд Монгол,Түрэг аймгууд хамт 400 орчим жил оршин сууж, өнөржин олширсон

ХОЁР: Харгалзуулах даалгавар / боноо/

1. Дараах тестийг тохируулаарай.

- | | |
|--|------------------------------------|
| 1. Ан агнах ургамал түүхэд хэрэглэхийн тулд | а.Хэл зохиов. |
| 2. Ан агнах шинэ газар нутаг эрж хайхын тулд | б.Ан амьтан зурдаг байв. |
| 3. Харилцах шаардлагтай байсан тул | в.Багаж зэвсэг хийдэг байв |
| 4. Ан ав нь амжилттай болоосой гэж бодож | г.Газар нутагт тархан нүүдэг байв. |

2. Монгол нутаг дах эртний нүүдэлчдийн дурсгалын тайлбарийг тохируулаарай.

- | | |
|-------------------|---|
| 1. Дөрвөлжин булш | а. Гонзгой урт чулууг засаж өнгөлөн, дээд хэсэгт нар, сар хөшөөний их биеийг ороолгон бугыг дүрсэлсэн хөшөө |
| 2. Хиригсүүр | б. Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж |
| 3. Хадны зураг | в. Дөрвөлжин дугуй хүрээ чулуутай, голдоо дугуй чулуун дараас бүхий эртний булш |
| 4. Буган хөшөө | г. Эртний хүмүүс амьдрал ахуйгаа хад чулуунд зураглан бичиглэсэн түүх |

3.Дараах түүхэн дурсгалуудыг холбогдох эртний улстай тохируулаарай

- | | |
|-----------|---|
| 1. Хүннү | а. Ховд аймаг дах Хуягт морин цэргийн хадны зураг |
| 2. Сяньби | б. Архангай аймаг дах Культегины гэрэлт хөшөө |
| 3. Түрэг | в. Хүн чулуу |
| 4. Уйгар | г. Ноён уулын язгууртны булш |

4.Түүхийн олдворуудыг газар нутагтай нь тохируулаарай.

- | | |
|-------------------------------|--------------------|
| 1. Хүннүгийн язгууртны булш | а. Ховд аймаг |
| 2. Ямаан усны хадны зураг | б. Архангай аймаг |
| 3. Адуун сүргийн дүрс | в.Баянхонгор аймаг |
| 4. Оюу шигтгээт алтан чимгүүд | г. Төв аймаг |

5.Эртний Грекийн бурхадыг зөв тохируулна уу.

- | | |
|-----------|-------------------------------|
| 1.Посидон | а. Бурхдын хаад Аянгын бурхан |
| 2.Зевс | б. Тэнгисийн бурхан |
| 3.Аполлон | в. Нарны бурхан |
| 4.Арес | г. Дайны бурхан |

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 6 ДУГААР АНГИЙН ТҮҮХ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

6..... ангийн сурагч овогтой
ХУВИЛБАР Б

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ 100 ОНОО

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР /Даалгавар бүр 2 оноотой/

- Хүний анхны өвөг /австролопитек/ аль тивд эхэлж үүссэн бэ?
а. Ойрхи Дорнод б. Баруун Европ в. Хятад г. Африк
- Газар тариалан хэзээ үүссэн бэ?
а. НТӨ-10000 жил б. НТӨ-6000 жил в. нтө-8000жил г. НТӨ-7000жил
- Хүн төрөлхтний түүхийг түүхийн шинжлэх ухаанд хэрхэн үечилдэг вэ?
а. Палеолит, Мезолит, Неолит
б. Хуучин үе, Дунд үе, Шинэ үе, Орчин үе
в. Түүвэрлэх үе, Мал аж ахуйн үе, Технологийн үе
г. Эртний үе, Дундад зууны үе, Шинэ үе, Орчин үе
- “Неолит” гэдэг нь чулуун зэвсгийн аль үеийг нэрлэж байна вэ?
а. Шинэ чулуун зэвсэг б. Дунд чулуун зэвсэг
в. Хуучин чулуун зэвсэг г. Хүрэл зэвсэг
- Өөрийн төрсөн өдрөө тодорхойлъя.
 он зуун
а. 2012он, 21 зуун б. 2012он, 22зуун в. 2012он, 20зуун г. 2012он, 19зуун
- “Австролопитек” хэдээс хэдэн сая жилийн хооронд амьдарч байсан бэ?
а. 5-1.3 сая б. 2.4-1.6 сая в. 1.5-0.3 сая г. 0.3-0.1 сая
- Дараах онуудын аль нь цаг хугацааны хувьд эртнийх вэ?
а. НТӨ-30 он б. НТ-30 он в. НТӨ-300 он г. НТ-300 он
- Анхы бичиг үсэг хэдийд үүссэн бэ?
а. НТӨ-3200-3100 он б. НТӨ-5000 он в. НТӨ-4000 он г. НТӨ-3000 он
- Хүннү улсын хаан хэн бэ?
а. Таньшихуа б. Моюнчур в. Модун Шаньюй г. Шэлүнь
- Аль нь хүн төрөлхтний суурин иргэншил үүссэн уугуул нутаг аль нь биш вэ?
а. Тигр, Евфрат б. Нил в. Амазон г. Шар мөрөн
- Хүн төрөлхтний анхны бичиг үсэг хаана хэзээ үүссэн бэ?
а. Вавилонд НТӨ 6000-5000 б. Хятадад НТӨ 3800-3600
в. Шүмэр НТӨ 3200-3100 г. Египетид НТӨ-1600 он

12. “Эрчүүд нь эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандах ёстой ч эмэгтэйчүүд гэртээ эрчүүдийн хүслээр амьдрах ёстой” хэмээн ямар хуульд заасан байдаг вэ?
- а. Манугийн хууль б. Хаммурапи хааны хууль
в. 12 Зэс самбарын хууль г. Их засаг хууль
13. Хадны зураг нь аль үеийн дурсгал вэ?
- а. Шинэ чулуун зэвсгийн үе б. Хүрэл ба Төмөр зэвсгийн үе
в. Хуучин чулуун зэвсгийн үе г. Дундад чулуун зэвсгийнүе
14. Уг эх сурвалжийг зосон ба сийлмэл гэж 2 ангилдаг. Тохирох хариултыг сонгоно уу.
- а. Түүвэр олдвор б. Урлаг в. Хадны зураг г. Чулуун зэвсэг
15. Эртний Энэтхэгийн иргэншил ямар мөрний хөндийг даган үүссэн бэ?
- а. Инд мөрөн б. Нил мөрөн в. Шар мөрөн г. Хоёр мөрөн
16. Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж аль нь вэ?
- а. Хиригсүүр б. Бунхан в. Дөрвөлжин булш г. Гэр булш
17. Вавилон улсын оршин тогтнож байсан хугацаа аль нь вэ?
- а. НТӨ 3200-2350 б. НТӨ 2060-НТӨ1500 в. НТӨ1500-500 г. НТӨ 2000-НТӨ 539
18. Инд мөрний хөндийд анх бий болсон хотууд аль нь вэ?
- а. Тенис, Мемфис б. Ур, Урук в. Хараппа, Мохенжо-Даро г. Фив, Ниппур
19. Хятадын "Цагаан хэрэм"-ийг барих болсон шалтгаан юу вэ?
- а. Вэй улсын довтолгооноос хамгаалахын тулд
б. Чингис хааны довтолгооноос хамгаалахын тулд
в. Хүннүчүүд болон тэр үеийн нүүдэлчдийн довтолгооноос хамгаалахын тулд
г. Умард Алтан улсын довтолгооноос хамгаалахын тулд
20. “Олигарх” засаглал гэж ямар засаглал вэ?
- а. Олонхийн засаглал б. Цөөнхийн засаглал
в. Хаант засгалал г. Дарангуйлалын засгалал
21. Хүн төрөлхтний эртний иргэншил үүссэн Тигр, Евфрат мөрнүүд хаанаас эх авч хаана цутгадаг вэ?
- а. Төвдийн тэгш өндөрлөгөөс эх авч Шар тэнгис цутгана
б. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч Газар дундын тэнгист цутгана.
в. бага Азийн өндөр уулсаас эх авч Персийн буланд цутгана
г. Андын нуруунаас эх авч Атланьын далайд цутгана
22. Хүннү улс НТ 93 онд мөхжээ. Оныг зуунд шилжүүлнэ үү
- а. НТӨ II зууны I хагас б. НТӨ III зууны I хагас
в. НТ II зууны II хагас г. НТ I зууны II хагас
23. Хүннү улсын оршин тогтнож байсан хугацаа аль нь вэ?
- а. НТӨ 209-НТ 93 он б. НТӨ II-I зуун в. 333-555 он г. 555-745 он
24. Түрэг угсааны эртний улсуудаас хамгийн удаан оршин тогтносон нь аль вэ?
- а. Уйгар б. Түрэг в. Киргиз г. Динлин
25. Хүннүгийн үндсэн аж ахуй нь.....
- а. Газар тариалан б. Мал аж ахуй в. Гар урлал г. Ан агнуур

26. Монгол нутаг дахь эртний улсуудыг оршин байсан дарааллаар нь зөв эрэмбэлснийг олно уу.
- а. Хүннү,Сянби, Нирун,Уйгар, Түрэг
б.Хүннү,Сянби,Нирун,Түрэг,Уйгар
в. Хүннү,Нирун, Сянби,Түрэг, Уйгар
г.Хүннү,Сянби,Уйгар,Түрэг,Нирун
27. Хүннү улс мөхөх болсон шалтгааныг доорх өгөгдлөөс сонгоно уу.
- а. Хөрш орнуудын довтолгоо
б.Түүний харьяанд байсан ард түмнүүдийн бослого
в.Олон жил үргэлжилсэн ган зуд
г. Хаан ширээний төлөөх дотоодын
28. Цэгийн оронд нөхөж бичнэ үү
- Нар, сар хэлбэрт ялтсан алтан чимэг нь.....улсын үед холбогдох бөгөөд.....байсныг илтгэнэ.
- А. Хүннү бурханы шашин шүтдэг
Б. Хүннү бөөгийн шашин шүтдэг
в. Түрэг бөөгийн шашин шүтдэг
г. Түрэг бурханы шашин шүтдэг
29. Хойд цэнхэрийн агуйн зурагт дүрслэгдсэн амьтдыг харахад тэр үед Монгол орны уур амьсгал ямар байсныг сонгоно уу.
- а.Мөстлөгийн үеийн буюу хүйтэн уур амьсгалтай
б. Эрс тэс уур амьсгалтай
в. Халуун хуурай уур амьсгалтай
г. Чийглэг дулаан уур амьсгалтай
30. 1991 онд Альпийн нуруунаас 5200 жилийн өмнө амьдарч байсан хүнийг олж Өтци хэмээн нэрлэсэн. Энэ хүн чулуун зэвсгийн аль үед амьдарч байсан бэ?
- а. Хуучин чулуун зэвсгийн үеийн хүн
б. Дунд чулуун зэвсгийн үеийн хүн
в. Шинэ чулуун зэвсгийн үеийн хүн
г. Хүрэл зэвсгийн үеийн хүн
31. Манай орны чулуун зэвсгий хамгийн сонирхолтой хадны зураг Ховд аймгийн Хойд цэнхэрийн агуйд бий. Энэ нь түүхийн ямар эх сурвалжид хамаарах вэ?
- А. Бичгийн эх сурвалж
Б. Эд өлгийн эх сурвалж
в. Аман сурвалж
г. аль нь ч биш
32. Эртний хүмүүс хэдий үеэс нум сум хийж сурсан бэ?
- а. Хуучин чулуун зэвсгийн эхэн үе
б. Дунд чулуун зэвсгийн сүүл үе
в. Хуучин чулуун зэвсгийн дунд үе
г. Шинэ чулуун зэвсгийн эхэн үе
33. Хүмүүс зэрлэг ан амьтдыг гаршуулж, түүнийг аж ахуйдаа ашиглаж эхэлжээ. Энэ нь аль үед хамаарах вэ?
- а. Дунд чулуун зэвсгийн үе
б.Шинэ чулуун зэвсгийн үе
в.Хуучин чулуун зэвсгийн үе
г. Хүрэл зэвсгийн үе
34. Уг эх сурвалжийг зосон ба сийлмэл гэж 2 ангилдаг. Тохирох хариултыг сонгоно уу
- а. Түүвэр олдвор
б. Урлаг
в. Хадны зураг
г. Чулуун зэвсэг

35. Эргүнэ гүний домгийн гол агуулгыг зөв тодорхойлсныг сонгоно уу.

- а. Түрэг аймгийг Монголчууд цохин мөхөөж тэд Эргүнэ гүнд очиж нутагласан
- б. Түрэгүүдэд цохигдсон Монголчууд Эргүнэ гүнд очиж нутаглан өсөж үржсэн
- в. Эргүнэ гүнд Монголчууд 1000 орчим жил амьдарсан
- г. Эргүнэ гүнд Монгол, Түрэг аймгууд хамт 400 орчим жил оршин сууж, өнөржин олширсон

ХОЁР: Харгалзуулах даалгавар / боноо/

1. Түүхийн олдворуудыг газар нутагтай нь тохируулаарай.

- | | |
|---|---------------------------|
| 1. Өтциг олсон | а. Хоёр мөрний хөндийгөөс |
| 2. Шавар самбар олсон | б. Альпийн нуруунаас |
| 3. Хамгийн эртний орчин үеийн хүний ул мөр | в. Африкаас |
| 4. 3,5 сая жилийн өмнө амьдарч байсан хүний араг яс олсон | г. Танзаны Лэтилогоос |

2. Монгол нутаг дах эртний нүүдэлчдийн дурсгалын тайлбарийг тохируулаарай.

- | | |
|-------------------|---|
| 1. Дөрвөлжин булш | а. Гонзгой урт чулууг засаж өнгөлөн, дээд хэсэгт нар, сар хөшөөний их биеийг ороолгон бугыг дүрсэлсэн хөшөө |
| 2. Хиригсүүр | б. Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж |
| 3. Хадны зураг | в. Дөрвөлжин угуй хүрээ чулуутай, голдоо дугуй чулуун дараас бүхий эртний булш |
| 4. Буган хөшөө | г. Эртний хүмүүс амьдрал ахуйгаа хад чулуунд зураглан бичиглэсэн түүх |

3. Эртний улсуудыг тухайн улстай холбоотой нэртэй нь зөв тохируулаарай.

- | | |
|------------|----------------------------|
| 1. Хятад | а. Каст |
| 2. Энэтхэг | б. Бүгд найрамдах засаглал |
| 3. Ром | в. Амфи театр |
| 4. Грек | г. Байлдаант улсын үе |

4. Дараах түүхэн дурсгалуудыг холбогдох эртний улстай тохируулаарай

- | | |
|-----------|---|
| 1. Хүннү | а. Ховд аймаг дах Хуягт морин цэргийн хадны зураг |
| 2. Сяньби | б. Архангай аймаг дах Культегины гэрэлт хөшөө |
| 3. Түрэг | в. Хүн чулуу |
| 4. Уйгар | г. Ноён уулын язгууртны булш |

5. Дараах тестийг тохируулаарай.

- | | |
|--|------------------------------------|
| 1. Ан агнах ургамал түүхэд хэрэглэхийн тулд | а. Хэл зохиов |
| 2. Ан агнах шинэ газар нутаг эрж хайхын тулд | б. Ан амьтан зурдаг байв |
| 3. Харилцах шаардлагтай байсан тул | в. Багаж зэвсэг хийдэг байв |
| 4. Ан ав нь амжилттай болоосой гэж бодож | г. Газар нутагт тархан нүүдэг байв |

